

**МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

20 **23** оны **07** сарын **25** өдөр

Дугаар **23122**

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр томилох тухай

Монгол Улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.7 дэх заалтууд, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Даатгалын хорооны 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн дүгнэлтийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Монгол Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр Лхагважавын Төр-Одыг 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс томилсугай.
2. Лхагважавын Төр-Одод нэгдүгээр гарын үсэг зурах эрхийг үүгээр олгосугай.
3. Нэргүйн Батбаярын компанийн хоёрдугаар гарын үсэг зурах эрхийг хүчингүй болгож компанийн хоёрдугаар гарыг үсэг зурах эрхийг Баатарын Нарантуяад олгосугай.
4. Лхагважавын Төр-Одыг эрх бүхий албан тушаалтнаар бүртгүүлэх зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн бүрдүүлж Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлэхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Т.Цацрал)-д үүрэг болгосугай.
5. Санхүүгийн Зохицуулах Хорооноос эрх бүхий албан тушаалтыг томилох зөвшөөрөл бичгээр ирсэн тохиолдолд Лхагважавын Төр-Одыг гүйцэтгэх захирлаар томилогдсонд тооцож хөдөлмөрийн гэрээ байгуулах ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулахыг Захиргаа, Хүний нөөцийн хэлтэс (Б.Нарангоо)-т үүрэг болгосугай.
6. Лхагважавын Төр-Одтой цалин, урамшуулал, нөхцөл, хариуцлагын хэмжээг тохиролцож, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нэрийн өмнөөс гэрээ байгуулахыг ТҮЗ-ийн дарга (ГРОМОВ С.Б.)-д үүрэг болгосугай.
7. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан харилцагч банкууд болон бусад байгууллагад мэдэгдэж, холбогдох гэрээ, баримт бичигт өөрчлөлт оруулахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Л.Төр-Од)-д даалгасугай.
8. Энэхүү тогтоолтой холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01/03 тоот тогтоолыг хүчингүй болгосугай.
9. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Т.Цацрал)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ГРОМОВ С.Б.



Буухиа даатгал: +976 7010-1990
Даатгалын лавлах: +976 1800-1990



www.mongoldaatgal.mn
insurance@mongoldaatgal.mn